



**МОНГОЛ УЛСЫН  
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
БИОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН**



**БИОЛОГИЙН  
ХҮРЭЭЛЭНГИЙН  
ДУНД ХУГАЦААНЫ  
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ  
(2018-2025 он)**

Улаанбаатар хот

2017 он

**МОНГОЛ УЛСЫН  
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
БИОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН**

**БИОЛОГИЙН  
ХҮРЭЭЛЭНГИЙН  
ДУНД ХУГАЦААНЫ  
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ  
(2018-2025 он)**

Шинжлэх Ухааны Академийн Тэргүүлэгчдийн  
2017 оны ... дугаар сарын ...-ны өдрийн  
хурлаар хэлэлцэн батлав

Улаанбаатар хот

2017 он

*Монгол улсын Засгийн газрын 2019 оны 8-р сарын 14 -ны өдрийн 368-р тогтоолоор тус хүрээлэн бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөд орж, Биологийн хүрээлэн байгуулагдсантай холбогдуулан Шинжлэх Ухааны Академийн Тэргүүлэгчдийн 2017 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн дунд хугацааны 2018-2025 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан шинэчлэн боловсруулав.*

**Утас: 11-453088, 11-451781**


**Web: [biology.ac.mn](http://biology.ac.mn)**

**Email: [biology@mas.ac.mn](mailto:biology@mas.ac.mn)**



## АГУУЛГА

Нэг. Стратеги төлөвлөгөө боловсруулах үндэслэл, ач холбогдол .....	3
Бодлогын хүрээ .....	3
Хоёр. Хүрээлэнгийн үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ .....	4
2.1. Гадаад орчин.....	4
2.2. Дотоод орчин.....	7
Гурав. Чиг үүрэг, үндсэн чиглэл .....	9
3.1. Чиг үүрэг.....	9
3.2. Үндсэн чиглэл.....	9
Дөрөв. Хүрээлэнгийн хөгжлийн төлөв, онол аргазүйн төвшин .....	10
4.1. Хүрээлэнгийн хөгжлийн төлөв байдал .....	10
4.2. Хүрээлэнгийн суурь судалгааны онол арга зүйн төвшин .....	11
Тав. Хөгжлийн стратеги, ерөнхий зорилго.....	13
5.1. Алсын хараа, Эрхэм зорилго, Эрхэмлэх зүйлс .....	13
5.2. Стратеги төлөвлөгөөний зорилтууд.....	14
5.3. Хөгжлийн үйл ажиллагааны зорилтууд.....	14
5.4. Үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжүүлэх үе шат .....	16
Зургаа. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн хүрээ, боломж ....	25







## НЭГ. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, АЧ ХОЛБОГДОЛ

Нэгдсэн үндэсний байгууллага “Даян дэлхийн тогтвортой хөгжил -2030” –баримт бичгийг баталж, Монгол улсын Засгийн газар XXI зууны тогтвортой хөгжлийн үндэс болсон экологийн баримжаатай эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх зорилтыг хангахын тулд дэс дараатай олон чухал зорилт, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, Монгол улсын Их Хурал 2016 онд “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030”, Монгол улсын Засгийн газар 2017 онд “Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого”-оо шинэчлэн батлаад байна.

Шинжлэх ухааны Академийн Биологийн хүрээлэн биологийн шинжлэх ухааны хөгжлийн чиг хандлага, улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн байгууллагын хувьд бэхжин хөгжих дунд хугацааны стратегийн төлөвлөгөөгөө боловсрууллаа.

Монгол улсын Шинжлэх Ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хууль, Шинжлэх ухаан технологийн тухай хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ конвенци, бүс нутгийн хэмжээний байгаль орчин, биологийн олон янз байдлыг хамгаалах, нөөц баялагийг зохистой ашиглах бодлогын баримт бичгүүд, Шинжлэх ухаан технологийн талаар баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрүүдийн зорилт, нийтлэг шаардлагуудад нийцүүлэн хүрээлэнгийн стратеги зорилтыг тодорхойлон хэрэгжүүлэх, ШУА-ийн Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөр, хүрээлэнгийн захирлын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, байгууллагын өнөөгийн нийгэмд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх бодлогыг боловсруулан хэрэгжилтийг хангах нь тус хүрээлэнгийн нэн тэргүүний зорилт арга хэмжээний нэг болж байна.

ШУА-ийн Биологийн хүрээлэн нь Монгол орны амьтны аймаг, бичил биетний олон янз байдлыг хадгалах, экологи биологи онцлогийг эс, эд, бодгаль, популяцийн төвшинд уламжлалт болон орчин үеийн молекул-биологийн онолын суурь судалгааны аргаар явуулж, биологийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах үүрэг бүхий төсвийн мэргэшсэн байгууллага юм.

Хүрээлэн байгууллагын гадаад, дотоод орчинд дүн шинжилгээ хийж, давуу болон сул талаа тодорхойлон өнгөрсөн-одоо-ирээдүй буюу ахмад-дунд-залуу үеийн холбоо, үнэт зарчимдаа тулгуурлан алсын хараа, ирээдүйд хүрэх эрхэм зорилгоо зөв томъёолон, судалгаа шинжилгээний ажлын тэргүүлэх чиглэл, стратеги зорилтуудыг үе шаттайгаар тодорхойлон үйл ажиллагаагаа нэгдмэлээр явуулах шаардлага бидэнд тулгарч байна.

### **Бодлогын хүрээ**

Монгол улсын төр засгаас Байгаль орчны холбогдолтой бодлогын баримт бичгүүдэд байгаль дэлхийтэйгээ зохицон амьдарч, байгалийн нөөцийг тогтвортой ашиглаж, нөхөн сэргээж, экологийн тэнцвэртэй аюулгүй орчинд амьдарч ажиллах зорилтыг дэвшүүлж, “Ногоон хөгжил”-ийн бодлогыг улс орны хөгжлийн тулгуур бодлогын нэг болгон, “Ногоон эдийн засаг”-ын тогтолцоог бүрдүүлж, экологид ээлтэй тэргүүлэх арга, технологи,



шинжлэх ухааны ололтыг судалж нутагшуулах, дотоодын судалгаа шинжилгээ, технологи боловсруулах чадавхыг дээшлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр заасан.

Монгол улс Байгаль орчин, биологийн олон янз байдлыг хамгаалах, нөөц баялагийг зохистой ашиглах Олон улсын гэрээ конвенцид нэгдэн орж, Засгийн газраас Биологийн олон янз байдал, нөөцийг хамгаалах үндэсний хөтөлбөрүүдийг боловсруулсны дотор тус хүрээлэнгийн үйл ажиллагаатай шууд холбоотой дараах Олон улсын гэрээ конвенци, үндэсний хөтөлбөрүүд байна. Үүнд:

- Биологийн төрөл зүйлийн тухай конвенц 1993.06.01
- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь Конвенц 1993.06.01
- Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц /CITES/ 1995.05.04
- Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай /Рамсарын конвенц/ 1997.06.05
- Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай Боннын конвенц 1999.06.24
- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь Конвенц ийн Киотогийн протокол 1997.07.08
- Био-аюулгүй байдлын тухай Картагенийн Протокол
- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоол
- Төрөөс экологийн талаар баримтлах бодлого Монгол Улсын Их Хурлын 1997 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 106 дугаар тогтоол
- Төрөөс Шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого- Засгийн газрын 2017 оны 295 дугаар тогтоол
- Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалт (2015-2021) Засгийн газрын 2015 оны 368 дугаар тогтоолын хавсралт
- “Ногоон хөгжлийн бодлого” Монгол Улсын Улсын Их Хурлын 2014 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 43 дугаар тогтоол
- “Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр” Засгийн газрын 2011 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 277 дугаар тогтоол
- “Биологийн олон янз байдлын тухай үндэсний хөтөлбөр” Засгийн газрын 2015 оны 08 дугаар сарын 04-ны өдрийн 325 дугаар тогтоол зэрэг болно.

Монгол улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ конвенцийн хүрээнд хүлээсэн үүрэг, Монгол улсын Их Хурал, Засгийн газрын баталсан үндэсний хөтөлбөрүүд болон Шинжлэх Ухаан, Технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, Цөм технологийн бодлогын баримт бичгүүдэд заасан тус хүрээлэнгийн үйл ажиллагаатай шууд холбоотой дор дурдсан зарим зорилтын хэрэгжилтийг хангахад бидний оролцоо нэн чухал байх болно. Үүнд:

- Дэлхийн байгалийн бүс, бүслүүрийн үндсэн хэв шинж, өвөрмөц бүрдэл хэсгийг төлөөлж чадах ховор, ховордсон төрөл зүйлээс бүрдсэн Монгол орны амьтны аймаг нь экологийн тэнцлийг хангах, биологийн төрөл зүйлийн тэнцвэрийг хадгалах, хүн амын хүнсний нөөцийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтойг харгалзан байгалийн ургамал, зэрлэг амьтдын удмын санг хамгаалж, боломжтойг нь нөхөн сэргээх замаар үр өгөөжийг нь хүн ам, аж ахуйн хэрэгцээнд зохистой ашиглах боломжийг бүрдүүлнэ;



- Байгаль цаг уурын өөрчлөлт, байгалийн гамшиг, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл, гоц халдварт өвчнөөс амьтны удмын сан, сүргийн бүтэц, амьдрах орчин, идээшил нутгийг хамгаалж хэвийн өсөлтийг нь хангах;
- Ховордсон, устах аюулд орсон амьтдыг байгаа орчинд нь гаршуулан тэжээж, өсгөн үржүүлэх, нөөц, тархац, амьтны тоо, байршил, агнуурын нөөцийг нь судалж экологи-эдийн засгийн үнэлгээний үндсэн дээр аж ахуйн ач холбогдол, ашиглалтын хэлбэр, зохион байгуулалтыг нь бүсчлэн тогтоож, элбэг амьтныг байгалийн хэвийн өсөлт, үржилтийг нь алдагдуулалгүй зохистой ашиглах, амьтны гаралтай үнэт түүхий эд, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр дэлхийн зах зээлд өрсөлдөх үндсэн агуулга бүхий зорилт арга хэмжээг урт хугацаанд хэрэгжүүлэх болно.

## ХОЁР. ХҮРЭЭЛЭНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Тус хүрээлэн нь гадаад, дотоод орчиндоо дүн шинжилгээ хийж, давуу болон сул талаа тодорхойлон цаашид хүрэх эрхэм зорилгоо зөв томъёолсноор Монгол улсын Засгийн газрын Шинжлэх, ухаан технологийг 2020 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн байгаль орчин, биологийн олон янз байдлын хүрээнд тавигдсан үндсэн зорилтуудын гүйцэтгэл, биелэлтэд голлон оролцох манлайлагч байр суурьтай байгууллага байх ёстой юм.

### 2.1. Гадаад орчин

#### Хууль эрхзүйн орчин

Тус хүрээлэн өөрийн үйл ажиллагаандаа дараах хууль эрхзүйн баримт бичгүүдийг мөрдөн удирдлага болгон ажиллана. Үүнд:

- Монгол улсын шинжлэх ухаан, технологийн тухай хууль, 1998
- Шинжлэх ухааны академийн эрхзүйн байдлын тухай хууль, 1996
- Инновацийн тухай хууль
- Патентын тухай хууль
- Монгол улсын төсвийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомж
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995
- Амьтны тухай хууль, 2012
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
- Хувиргасан амьд организмын тухай хууль 2007
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, 2012
- Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенци. 1996.5.1
- Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах Боннын конвенци. 1999.6.24
- Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенци. 1998.4.8
- Биологийн олон янз байдлын тухай НҮБ-ын суурь конвенци. 1993.9.30
- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенци. 1993.09.30
- Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээр. 2016.9.01





- Биологийн төрөл зүйлийн тухай конвенцийн био аюулгүй байдлын тухай Картагений протокол.2002.11.07
- Биологийн олон янз байдлын тухай конвенцийн Генетик нөөц болон тэдгээрийг ашигласнаас үүдэх үр ашгийг шударга, эрх тэгш хуваарилах тухай Нагоягийн протокол. 2012.12.20
- Биоаюулгүй байдлын тухай Картагены Протоколын Хариуцлага тооцох ба хохиролгүй болгох тухай Нагоя-Куала Лампурын Нэмэлт Протокол. 2012.12.20
- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай конвенцийн Киотогийн протокол.1997

Боломж	Аюул занал, эрсдэл
<p>Шинжлэх ухааны байгууллагын үйл ажиллагаанд хэд хэдэн давуу тал байгааг тогтоожээ. Тэдгээр боломжуудыг дараах байдлаар авч үзэж болох юм. Үүнд:</p> <p><b>Нэгдүгээрт</b> Эрдэм шинжилгээний байгууллагын үйл ажиллагаа нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд шууд болон дам нөлөө үзүүлж чаддаг онцлогтой.</p> <p><b>Хоёрдугаарт</b> Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд XXI зууны тогтвортой хөгжлийн чиг зорилгод экологийн баримжаат эдийн засгийг хөгжүүлэх зорилт томъёологдсон нь байгаль орчиндоо зохицон тогтвортой хөгжих, улмаар дэлхий нийтийн чиг хандлагад нийцүүлэн эх орныхоо байгаль, экологийн нөхцлийг судлан илрүүлж, байгалийн ялангуяа биологийн нөөц баялгийг зохистой ашиглах замаар улс орныг тогтвортой хөгжүүлэх урт хугацааны бодлогыг тодорхойлсон болно.</p> <p><b>Гуравдугаарт</b> Байгаль хамгаалах, доройтсон орчныг нөхөн сэргээх, биологийн нөөц, баялгийг зохистой ашиглах, үр өгөөжийг нь нэмэгдүүлэх харилцааг зохицуулсан хуулиудыг батлан гаргасан явдал байгаль орчны талаархи судалгаа, шинжилгээний ажлыг хууль эрхзүйн шинэ орчинд зохицуулан явуулах нөхцөлийг бүрдүүлжээ.</p>	<p>Экологи байгаль орчны судалгаанд тулгамдаж буй хурц асуудлууд (аюул занал, эрсдэл)-г дараах байдлаар авч үзэж болно.</p> <p><b>Нэгдүгээрт</b> Дэлхийн цаг уурын дулааралт, хүний үйл ажиллагааны улмаас цөлжилт ихсэж, биологийн нөөц баялаг хомсдон экологийн тэнцвэрт байдал алдагдсан нь судалгааны ажлын үндсэн чиглэлүүдийг эрс өөрчлөн тэдгээрт ихээхэн хөрөнгө хүн хүч шаардах боллоо.</p> <p><b>Хоёрдугаарт</b> Эрдэм шинжилгээний байгууллагын төсвийн санхүүжилт бага, гадаадын технологи өндөр хөгжсөн улс оронд суралцаж мэргэшсэн, өндөр түвшинд бэлгэгдсэн боловсон хүчний нөөцийг зохистой ашиглах, ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах эдийн засаг санхүүгийн болон лаборатори тоног төхөөрөмж, эм урвалжийн хангамж хүрэлцээгүй хязгаарламал ажиллах боломжгүй байгаа зэрэг нь тус хүрээлэнг олон улсын түвшнээс хоцрогдоход хүргэж байна.</p> <p><b>Гуравдугаарт</b> Байгаль орчин, экологийн судалгаа шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, зохицуулалтын механизмьг төгөлдөржүүлэх шаардлага гарч байна.</p>

### Шийдвэрлэвэл зохих асуудал, саад бэрхшээл

Тус хүрээлэнгийн гадаад орчинтой холбоотой тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх арга замыг нээн тэдгээрийг дэс дараатайгаар оновчтой авч хэрэгжүүлэх нь биологийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, байгалийн амьтан, ургамал, бичил биетний нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх судалгааны ажил явуулах таатай нөхцлийг бүрдүүлнэ. Тэдгээр асуудлуудыг дараах байдлаар багцлан авч үзэж болох юм. Үүнд:

а) Биологийн салбарыг тус улсын амьтан судлал, биотехнологийн талаарх аливаа асуудлын гол толгойлогч, зохицуулагч, шинжлэн судлагч, магадлан шинжээч байхаар хууль эрхзүйн зохицуулалт хийх; Амьтны аймаг, бичил биетний салбар мэдээллийн санг тус хүрээлэнд төвлөрүүлэн хариуцуулан ажиллуулах

б) Байгаль орчин, амьтан, бичил биетэн судлал, генетик, молекул биологи, биотехнологи, экологийн чиглэлээр судалгааны ажлын төлөвлөлт, эдийн засаг, зохицуулалтын механизмыг бүрдүүлэх;

в) Судалгааны материаллаг баазыг бэхжүүлэх, олон улсын түвшинд хүрэхүйц лаборатори, өндөр нарийвчлал, хүчин чадалтай тоног төхөөрөмжөөр хангах;

г) Судалгааны ажлын санхүү, материалын болон хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх;

д) Хүрээлэнд инноваци, бизнесийн орчинг бүрдүүлэх;

е) Эрдэм шинжилгээний байгууллагуудтай мэдээлэл, ажлын үр дүнгээ солилцох ба тэдгээрийн хооронд ажлын уялдаа холбоо сайжруулах;

ё) Салбар болон холбогдох яамдын хооронд экологи, биологи, байгаль орчны судалгааны үр дүнг хүлээн авах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг зохицуулах, мэдээлж тайлагнах нэгдсэн системийг төлөвшүүлэх;

### 2.2. Дотоод орчин

Давуу тал	Сул тал
<p>Биологийн хүрээлэнгийн үйл ажиллагааны давуу талыг доорхи байдлаар тодорхойлсон болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>• Биотехнологи, Зоологи болон Экологийн чиглэлээр судалгаа явуулах олон жилийн туршлагатай мэргэшсэн боловсон хүчний нөөцтэй.</li><li>• Монгол орны байгалийн үндсэн бүс бүслүүрт урт хугацааны мониторингийн судалгаа хийсэн буюу одоо хийгдэж байгаа хагас суурин, суурин судалгааны цэг нутгууд тогтоогдсон</li><li>• Мэргэжлийн номын сан, интернет, холбоо мэдээлэл сайн хөгжсөн сүлжээтэй</li></ul>	<p>Салбарын одоогийн үйл ажиллагаанд дор дурдсан сул талууд байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>• Гадаадын эрдэм шинжилгээний байгууллагатай эн тэнцүү хоршин ажиллах материаллаг бааз, санхүүгийн нөөц боломж хомс.</li><li>• Судалгааны үр дүнг харгалзан судлаачдыг урамшуулах механизмыг хараахан бүрэлдүүлж чадаагүй.</li><li>• Судалгааны ажлын үр дүнг олон нийтэд ил тод мэдээлэх явдал хангалтгүй;</li></ul>



- Дотоодын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллаж, өөрийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах болсон, тухайлбал Монгол-Оросын хамтарсан биологийн иж бүрэн экспедици 50 орчим жил ажиллаж байна.
- Монгол орны амьтны аймгийн холбогдолтой судалгааны шинжилгээний ажлыг 50 гаруй жил толгойлон гүйцэтгэж, төрд үйлчилж ирсэн баялаг туршлага, эрдэм шинжилгээний цуглуулгын сан, судалгааны ажлын материал эх хэрэглэхүүнтэй.
- Шинжлэх ухаан, судалгааны ажлын хууль эрх зүйн харьцангуй таатай орчин бүрдсэн.
- Монгол орны эрс тэс уур амьсгал, байгалийн нөхцөлд зохицсон Төв Азийн эндемик, Монголоос өөр нутагт байхгүй биологийн төрөл зүйл олонтой нь гадаадын судлаач эрдэмтдийн сонирхлыг ихээхэн татдаг.
- Монгол орны биологийн олон янз байдлын судалгааны бүхий л чиглэлээр гадаад хамтын ажиллагаа хөгжиж, технологи өндөр хөгжсөн улс оронтой хамтарсан судалгааны төслийг хэрэгжүүлдэг.
- Төв, орон нутгийн захиргааны удирдлага, тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлага бусад байгууллагуудтай хамтын ажиллагаа хөгжсөн.
- Судалгааны ажлыг гүйцэтгэх харьцангуй нэгдмэл уур амьсгал бүхий эрдмийн хамт олон бүрдсэн.
- Онолын суурь ба сорилын судалгааг өндөр түвшинд явуулах лабораторийн өндөр нарийвчлалтай тоног төхөөрөмж, багаж хэрэгслэл, эм урвалжийн хангамж нөөц хомсдолтой.
- Сорилын биологийн чиглэлээр мэргэшсэн гадаад (англи, герман, хятад г.м) хэлтэй, эрдмийн өндөр зэрэг цолтой боловсон хүчний тоо цөөн, өндөр мэргэжлийн хүний нөөцийн нөхөн сэлбэлт сул.
- Хавсарга судалгааны эзлэх хувь бага, бизнесийн орчин бүрдээгүй.
- Авъяаслаг эрдэмтэд, чадварлаг судлаач, боловсон хүчнийг мэргэшлийн өндөр түвшинд тогтвортой ажиллуулах нөхцөл хангалтгүй.
- Хүрээлэн болон салбарын яамдын хооронд судалгааны үр дүнг хүлээн авах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг зохицуулах, мэдээлж тайлагнах систем төлөвшөөгүй.
- Өндөр мэргэшсэн судлаачдыг урьж ажиллуулах санхүү, материаллаг баазын боломж хүндрэлтэй.



## ГУРАВ. ЧИГ ҮҮРЭГ, ҮНДСЭН ЧИГЛЭЛ

### 3.1. Чиг үүрэг

Байгаль орчиндоо зохицон хөгжих, экологийн баримжаатай эдийн засаг, нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх зорилтыг хангахын тулд Монгол орны биологийн нөөц баялагийн өвөрмөц онцлог, зүй тогтлыг судлан илрүүлж, биологийн шинжлэх ухааны онолын болон танин мэдэхүйн шинэ мэдлэг бий болгон олон нийтэд сурталчлан таниулах ба ирээдүйн эрх ашигт нийцүүлэн биологийн нөөц баялагийг зохистой ашиглах, хамгаалах, нөөцийг сэргээх, аж ахуйн болон аливаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулж төрийн бодлогод тусган хэрэгжүүлэх замаар төр түмэндээ үйлчлэх нь тус хүрээлэнгийн үндсэн үүрэг болно.

### 3.2. Үндсэн чиглэл

Монгол Улсын Засгийн Газар, Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яамны Сайдын 2015 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/337 дугаар тушаалд Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2015 оны “Шинжлэх ухааны байгууллагуудын талаар авах зарим арга хэмжээний тухай” 27 дугаар тогтоолын 2 дугаар заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ШУА-ийн Биологийн Хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэлийг тогтоосон. Үүнд:

1. Монгол орны амьтны аймгийн биологи, экологи онцлог, антропогенийн болон уур амьсгалын өөрчлөлт амьтны аймагт нөлөөлөх зүй тогтлыг судлан илрүүлж, амьд байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдал, биологийн олон янз байдлыг хадгалах, нөөц баялагийг хамгаалах, тогтвортой ашиглах шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах.
2. Монгол орны амьтны гарал үүслийг тогтоох, генийн сан бүрдүүлэх, сэргээн үржүүлэх генетик үндэслэл боловсруулах, эмийн болон ганд тэсвэртэй ургамлыг биотехнологийн аргаар үржүүлэх хоёрдогч метаболитын судалгаа хийх, хавдрын эсийг дарангуйлах ургамлын гаралтай биологийн идэвхит бодисыг судлах, хавдрын молекул механизм, шалтгааныг тогтоох, оношилгооны цомог гарган авах, хувиргасан амьд организмыг илрүүлэх.
3. Монгол орны бичил биетний ангилал зүй, генетик нөөцийг судалж, бичил биетний үндэсний сан бий болгох, инноваци, биотехнологийг тэтгэх ашигт өсгөврүүдийг илрүүлж, байгаль орчны бохирдлыг бууруулах, нөхөн сэргээх, хөрс сайжруулах, фермент, хүнс, тэжээлийн нэмэлт бэлдмэл, өвчин үүсгэгчийн эсрэг үйлчилгээтэй бүтээгдэхүүн гарган авах чиглэлийг тодорхойлсон


## ДӨРӨВ. ХҮРЭЭЛЭНГИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВ, ОНОЛ АРГАЗҮЙН ТӨВШИН

### 4.1. Хүрээлэнгийн хөгжлийн төлөв байдал

Тус хүрээлэн нь Амьтан судлал, Молекул биологи, Микробиологийн чиглэлээр онолын суурь судалгаа хэрэгжүүлдэг нийт 8 лаборатори болон Загас үржүүлгийн эрдэм шинжилгээний төв гэсэн үндсэн бүтэцтэй бөгөөд Монгол-Оросын хамтарсан биологийн иж бүрэн экспедицийн Монголын талыг хариуцан зохион байгуулах чиг үүргийг хүлээж, хээрийн туршилт судалгаа явуулах зориулалт бүхий хагас суурин, суурин (стационар) судалгааны төвтэй үйл ажиллагаа явуулж байна.

Хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монгол улсын ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлын 2019 оны 10 сарын 03-ны өдрийн 06 тоот тогтоолоор 3 академич, 3 шинжлэх ухааны доктор, 10 боловсролын доктор бүхий нийт 16 гишүүнтэйгээс 3 гишүүн нь их, дээд сургууль, гадны байгууллагын эрдэмтдийн төлөөлөл байхаар баталсан болно.

Захиргааны удирдлагыг захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, лабораторийн эрхлэгч нар, мэргэжил, арга зүйн удирдлагыг төслийн удирдагчид хэрэгжүүлнэ.



Зураг 1. Хүрээлэнгийн бүтэц зохион байгуулалт

2019 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлын 07 дугаар тогтоолоор Биологийн хүрээлэнгийн бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн баталсан болно.



## 4.2. Хүрээлэнгийн суурь судалгааны онол арга зүйн төвшин

ШУА-ийн Биологийн хүрээлэн нь Монгол орны биологийн олон янз байдал, түүний бүрэлдэхүүн хэсэг амьтны аймаг, бичил биетний биологи, экологи, генетик онцлог, хавдрын эсийн үржлийг дарангуйлагч бодисыг эмийн ургамлаас ялган цэвэршүүлэх, хавдар өвчний молекул механизм, генетик шалтгааныг тогтоох, шим мандлын хувьсал түүний амьдралыг тэтгэн буй системийг хамгаалах ач холбогдол, зүй тогтлыг судлан илрүүлж, биологийн нөөц баялагийг хамгаалах, тогтвортой ашиглах, үндэслэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний технологи бий болгох чиглэлээр эрдэм шинжилгээ, туршилт судалгааны ажлыг гүйцэтгэж байна.

### Генетикийн лаборатори

Монгол орны мал, биологийн төрөл зүйлүүдийн болон ховор болон устгах аюулд ороод буй мазаалай баавгай, монгол бөхөн зэрэг амьтдын генофондын судалгааг орчин үеийн молекул генетикийн аргаар хийж, ангилалзүй филогенетик холбоог тогтоон нөөцийг хамгаалах, ашиглах шинжлэх ухааны үндэслэл боловсруулахаас гадна зүйл, хүйсийн ялгааг генийн аргаар тодорхойлох арга зүйг нэвтрүүлэн ажиллаж байна.

### Молекул биологийн лаборатори

Монголын хүн амын дунд тархсан элэгний хавдрын судалгааг хепатитын В, С, D вирусын генотип онцлог болон эсийн олон төрлийн үйл ажиллагаанд оролцогч зарим генийн мутацитай харьцуулан хийж өвчлөх магадлалыг тодорхойлох, эрт зөв оношлох боломжийг олох, хувь хүний генетик онцлогоос шалтгаалж үүсч болох элэгний хавдрын молекул механизмыг судлахаар зорилт тавин жиллаж байна. Мөн Монгол адууны цусны дээжинд илэрсэн *Flaviviridae*-ийн овгийн *Herpesvirus* төрлийн шинэ вирусийн судалгаа, хувиргасан амьд организм тодорхойлох, биоаюулгүй байдлыг ханган хөгжүүлэх чиглэлээр ажиллаж байна.

### Микробиологийн лаборатори

Монгол орны бичил биетний ангилал зүй, генетик нөөцийг судалж, шинжлэх ухаанд шинэ мэдлэг бий болгох, ашигт шинж чанаруудыг тодорхойлж, эдийн засгийн төрөл бүрийн салбаруудын инноваци, биотехнологийг тэтгэх өсгөврүүдийг илрүүлэх, бичил биетний үндэсний сан бий болгож, *ex-situ* хадгалан хамгаалах чиглэлээр ажиллаж байна.

### Микробын нийлэгжлийн лаборатори

Биологийн идэвхт бичил биетнийг зүй зохистой ашиглаж, шинжлэх ухаан, нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой, байгальд ээлтэй технологи боловсруулж, биобүтээгдэхүүн гарган, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, байгаль орчны салбарт инновацийг хөгжүүлэх, биотехнологийн үйлдвэрлэлийн суурийг тавих чиглэлээр ажиллаж байна.

### Ургамлын биотехнологийн лаборатори

Ургамлын нөөцийг нэмэгдүүлэх, генофондыг хадгалах, ашигтай генийг таньж тодорхойлох, молекул биологийн аргазүй нэвтрүүлэх, генетикийн олон янз байдлыг



ашиглах зорилгоор ургамлын эс, эдийн өсгөвөр, генетик инженерчлэлийн чиглэлээр туршилт судалгааны ажил гүйцэтгэдэг.

## **Хөхтний экологийн лаборатори**

Монгол оронд өргөн тархсан экосистемд онцгой үүрэг бүхий монгол тарвага, цайвар үлийч, цагаан зээр, халиун буга, саарал чоно зэрэг хөхтөн амьтад, ховор, нэн ховор статус бүхий цоохор ирвэс, аргаль хонь, хавтгай тэмээ, мазаалай баавгай, монгол бөхөн, хулан адуу, жижиг махчид, зарим мэрэгчдийн биологи, экологи, физиологийн судалгааг явуулж эдгээр амьтдын экосистемд гүйцэтгэж буй үүрэг, популяцийн хөдлөл зүйг тодорхойлох, тогтвортой өсөн үржих, амьдрах орчныг сайжруулах, хамгаалах судалгааны ажлыг хийж онолын болон шинжлэх ухаан танин мэдэхүйн мэдлэг хуримтлуулан, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалахад чухал ач холбогдолтой хөхтний нөөцийг хамгаалах, зохистой ашиглах төр засгийн бодлогын шинжлэх ухааны үндэслэл санал зөвлөмжийг боловсруулах судалгааны ажлуудыг орчин үеийн судалгааны аргуудыг ашиглан гүйцэтгэж байна.

## **Шувуу, шавж судлалын лаборатори**

Монгол орны сээр нуруугүй амьтад, шувууны зүйлийн бүрдэл, тэдгээрийн оршин амьдрах хэлбэр, биологи, экологи онцлог, гарал, үүсэл, байгалийн бүс бүслүүр, газар зүйн тархалтын онцлогийг тогтоох, агнуурын болон ховор зүйл шувуудын тоо толгой, нөөц, ховордлын зэрэглэл, байгаль аж ахуйн холбогдлын талаарх суурь судалгааг хийж, ховор зүйл шувуудыг хамгаалах, зүй зохистой ашиглах арга замыг боловсруулан төр засгийн бодлого, шийдвэрт тусгах, Монгол орны шавьжийн байгалийн голлох экосистемүүд тухайлбал, ой, ойт хээр, хээр, говь, цөлд зонхилон тархах шавьжийн бүлгэмдлийн онцлогийг тодорхойлох, зарим зүйл шавьжийн тархацын зураглал гаргах, тархалтын зүй тогтлыг илрүүлэх чиглэлийн судалгааны ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

## **Гидробиологи, загас судлалын лаборатори**

Монгол орны усан орчны амьтан, ургамлын биологи, экологи, тархалт, нөөц, байгаль цаг уур, хүний нөлөөгөөр хувьсаж буй нуур, голын биоценозын өөрчлөгдлийг илрүүлэх, тэдгээрийг хамгаалах, зөв зохистой ашиглах боломж, шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулахад оршино.

## **Загас үржүүлгийн эрдэм шинжилгээний төв**

Монгол орны загасны болон ус нуурын биологийн олон янз байдлын бүрэлдэхүүн, тэдгээрийн идэш тэжээлийн холбоо, биоценозын хувьсал өөрчлөлт болон загасны нөөцийг зөв зохистой ашиглах, хамгаалах, загас, амьтан, ургамлыг нөхөн үржүүлэх шинжлэх ухааны үндэслэл боловсруулан ажиллаж байна.

**ТАВ. ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ, ЕРӨНХИЙ ЗОРИЛГО****5.1. АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ЭРХЭМЛЭХ ЗҮЙЛС****АЛСЫН ХАРАА:**

*Монгол улсын тогтвортой хөгжлийг бодит хувь нэмэр оруулсан, төр засгийн байгууллага, олон нийтэд шинжлэх ухаан, технологи, инновац, соён гэгээрүүлэх үйлчилгээг үзүүлэх, биологийн олон янз байдлын судалгааг эрхлэн дэлхийн эрчимт түвшинд хүрсэн, дүс нутгийн хэмжээнд нэр хүндтэй, өрсөлдөх тагвартай эрдэм шинжилгээний байгууллага болно.*

**ЭРХЭМ ЗОРИЛГО:**

*Монгол орны амьтны аймаг, дитим диетний олон янз байдлыг хадгалах, нөөц баялгийг өнөө да ирээдүйн эрх ашигт нийцүүлэн зохицой ашиглах, хатгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд гасан зохицох экосистемийн тэнцвэртэй байдлыг хангахад тиглэсэн инновац, шинэ мэдлэг дүй болгох суурь болон хавсарга судалгааг хослуулан хөгжүүлж монгол улсын тогтвортой хөгжлийг бодит хувь нэмэр оруулахад оршино.*

**ЭРХЭМЛЭХ ЗҮЙЛС:**

- Шинжлэх ухаанч байдал
- Академик эрх төлөө
- Нийгмийн харилцаа
- Уламжлал ба шинэчлэл
- Чанд сахилга бат
- Бүтээлт шуурхай байдал
- Нэгдмэл үйл ажиллагаа
- Мэдлэг тагвартай тэргээжилтэн
- Инновац шинэ технологи



## 5.2. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТУУД

№	Стратегийн зорилтууд
1.	Хүрээлэнгийн удирдлага, менежментийн оновчлол
2.	Судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг тодорхойлон хэрэгжүүлж үр дүнг дээшлүүлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх, шинэ мэдлэг түгээн дэлгэрүүлэх
3.	Хүний нөөцийг хөгжүүлж, судалгаа боловсруулалтын таатай орчин бүрдүүлэх
4.	Төлөвлөгөөт санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх
5.	Инноваци, гарааны компаний үйл ажиллагааг судалгааны үндсэн чиглэл, онцлогт уялдуулан хөгжүүлэх
6.	Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх

## 5.3. ХӨГЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТУУД

№	Стратегийн зорилтууд	Үйл ажиллагааны зорилтууд
I	Хүрээлэнгийн удирдлага, менежментийн оновчлол	1.1. Эрх зүйн орчныг шинэчлэн бүрдүүлэх санал боловсруулах, хүрээлэнгийн дүрэм, дотоод журамд шинээр батлагдсан хууль тогтоомжид нийцүүлэн тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулах
		1.2. Менежментийн чадавхид суурилсан удирдлагын тогтолцоо, үр ашиг бүхий бүтэц, зохион байгуулалтыг бүрдүүлэх
		1.3. Ажлын чанарын үнэлгээний стандартыг байгууллагын хөгжлийн шалгуур болгон хэрэгжүүлэх
II	Судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг тодорхойлон хэрэгжүүлж үр дүнг дээшлүүлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх, шинэ мэдлэг түгээн дэлгэрүүлэх	2.1. Суурь судалгаа, технологи, инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тодорхойлж, онолын судалгааны түвшинг дээшлүүлж, шинэ мэдлэг бий болгох үйл ажиллагааг дэмжих
		2.2. Монгол орны амьтны аймгийн гарал үүсэл, биологи, экологи онцлог, зүй тогтлыг судлан илрүүлж, экосистемийн тэнцвэрт байдал, биологийн олон янз байдлыг хадгалах, нөөцийг хамгаалах, ашиглах шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах
		2.3. Монгол орны биологийн олон янз байдлыг хадгалах, сэргээн үржүүлэх үндэслэл боловсруулах, ашигт ургамлыг биотехнологийн аргаар үржүүлэх хоёрдогч метаболитын судалгаа хийх, хавдрын эсийг дарангуйлах биологийн идэвхит бодисыг судлах, хавдрын молекул механизм, шалтгааныг тогтоох, оношлогооны цомог гаргах, хувиргасан амьд организмыг илрүүлэх
		2.4. Монгол орны бичил биетний ангилал зүй, генетик нөөцийг судалж, үндэсний сан бий болгох, ашигт өсгөврүүдийг



		илрүүлж, байгаль орчны бохирдлыг бууруулах, нөхөн сэргээх, хүнс, тэжээлийн нэмэлт бэлдмэл, өвчин үүсгэгчийн эсрэг үйлчилгээтэй бүтээгдэхүүн гарган авах
		2.5. Оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг нэмэгдүүлж, оюуны бүтээлийг эдийн засгийн эргэлтэнд оруулах
		2.6. Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээлийн чанарыг сайжруулах, олон улсын жишигт хүргэх, импакт фактор бүхий сэтгүүлд нийтлүүлэх өгүүллийн тоог нэмэгдүүлэх, судлаачдын бүтээлийн чанарыг сайжруулах
		2.7. Олон нийтийн экологийн боловсрол, биологийн шинжлэх ухааны мэдлэгийг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх, шинэ мэдлэг түгээн дэлгэрүүлэх
III	Хүний нөөцийг хөгжүүлж, судалгаа боловсруулалтын таатай орчин бүрдүүлэх	<p>3.1. Эрдэм шинжилгээний ажилтны мэдлэг, чадвар, бүтээлийг үнэлэх шалгуурыг шинэчлэн тогтоож, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх</p> <p>3.2. Эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтны ажиллаж, амьдрах нөхцөл, хангамжийг сайжруулах</p> <p>3.3. Лабораторийн баазыг олон улсын жишигт нийцүүлэн бэхжүүлэх</p> <p>3.4. Мэдээллийн технологийн орчин үеийн шаардлагад нийцсэн нарийн мэргэшлийн ном, товхимол бүхий уншлагын танхим байгуулах</p> <p>3.5. Хүрээлэнгийн барилга, байгууламжийг засварлах, өргөтгөх</p>
IV	Төлөвлөгөөт санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх	<p>4.1. Санхүүжилтийн тогтолцоог олон эх үүсвэрээс бүрдүүлэх, хүрээлэн-Монголд үйл ажиллагаа явуулдаг олон улсын төсөл хөтөлбөрүүд, орон нутаг, хувийн хэвшлийн түншлэлийг өргөтгөж, судалгаа, боловсруулалт, инновацийн үйл ажиллагааг өргөжүүлэх</p> <p>4.2. Томоохон зорилтыг шийдвэрлэхэд гадаадын төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг төвлөрүүлэх</p>
V	Инноваци, гарааны компаний үйл ажиллагааг судалгааны үндсэн чиглэл, онцлогт уялдуулан хөгжүүлэх	5.1. Судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэнд оруулах инновацийн тогтолцоог байгууллагын түвшинд бүрдүүлэх
VI	Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх	<p>6.1. Хил залгаа бүс нутаг, технологи өндөр хөгжилтэй улс орны болон олон улсын шинжлэх ухааны байгууллагуудтай хамтран ажиллах бодлого зохицуулалтын үйл ажиллагааг оновчтой төлөвлөж хамтын ажиллагааг өргөжүүлэх</p> <p>6.2. Монгол Оросын хамтарсан Биологийн иж бүрэн экспедици (МОХБИБЭ)-ийн хүрээнд хийх судалгааны ажлуудыг өргөжүүлэх, хамтын ажиллагааг идэвхжүүлэх</p> <p>6.3. Олон улсын нэр хүндтэй их сургууль, шинжлэх ухааны байгууллагатай хамтран мэргэжилтэн боловсон хүчин бэлтгэх, эрдэмтэн солилцоо хэрэгжүүлэх</p>



## 5.4. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Үйл ажиллагааны зорилтууд	Хэрэгжүүлэх төлөвлөгөөт арга хэмжээ	Үе шат	
		I шат 2018- 2021	II шат 2022- 2025
<b>I стратеги зорилт: ХҮРЭЭЛЭНГИЙН УДИРДЛАГА, МЕНЕЖМЕНТИЙН ОНОВЧЛОЛ</b>			
1.1. Эрх зүйн орчныг шинэчлэн бүрдүүлэх санал боловсруулах, хүрээлэнгийн дүрэм, дотоод журамд шинээр батлагдсан хууль тогтоомжид нийцүүлэн тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулах	1.1.1. Шинжлэх ухаан технологийн үйл ажиллагаа, байгаль орчныг хамгаалахтай холбоотой болон бусад эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулахад идэвх санаачлагатай оролцох	+	+
	1.1.2. Хүрээлэнгийн хөдөлмөрийн дотоод журам болон бусад дүрэм, журмыг иж бүрэн шинэчлэн мөрдөж ажиллах	+	+
	1.1.3. Инновацийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх, үүрэг бүхий ажилтан томилон ажиллуулах	+	
	1.1.4. Төр засаг, орон нутаг, хувийн хэвшлийн байгууллагатай тогтоосон хамтын ажиллагааг өргөжүүлэх	+	+
	1.1.5. Гадаадын төсөл, хөтөлбөр, олон улсын мэргэжлийн байгууллагын гишүүнчлэлийн тоог нэмэгдүүлэх	+	+
	1.1.6. Хэвлэл, мэдээллийн байгууллага, олон нийтийн мэдээллийн сүлжээнд шинжлэх ухаан технологийг сурталчлах	+	+
1.2. Менежментийн чадавхид суурилсан удирдлагын тогтолцоо, үр ашиг бүхий бүтэц, зохион байгуулалтыг бүрдүүлэх	1.2.2. Хүрээлэнгийн бүтэц, зохион байгуулалтын оновчтой хэлбэрийг бүрдүүлэх	+	
	1.2.4. Байгууллагын менежментийн чадавхийг бэхжүүлэх сургалт зохион байгуулах	+	+
1.3. Ажлын чанарын үнэлгээний стандартыг байгууллагын хөгжлийн шалгуур болгон хэрэгжүүлэх	1.3.1. Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ-үнэлгээний шалгуур үзүүлэлтийг боловсруулж мөрдөж ажиллах	+	+
	1.3.2. Байгууллагын чанарын удирдлагын стандартыг хэрэгжүүлэх	+	+
	1.3.3. Ажлын чанар, үр дүнгийн үнэлгээнд суурилсан цалин, урамшууллын системийг мөрдөх	+	+
<b>II стратеги зорилт: СУДАЛГААНЫ АЖЛЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙГ ТОДОРХОЙЛОН ХЭРЭГЖҮҮЛЖ ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ, ОЛОН НИЙТИЙГ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ, ШИНЭ МЭДЛЭГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ</b>			
2.1. Суурь судалгаа, технологи, инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тодорхойлж, онолын судалгааны түвшинг дээшлүүлж,	2.1.1. Эдийн засгийн бүтээмж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн суурь судалгаа, технологи, инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдийг шинэчлэн тодорхойлж хөгжүүлэх	+	+
	2.1.2. Аж үйлдвэрийн 4 дэх хувьсгалын хөгжилд нийцсэн шинжлэх ухаан,	+	+



шинэ мэдлэг бий болгох үйл ажиллагааг дэмжих	технологийн шинэ чиг хандлагыг хөгжүүлэхэд судалгааны ажлыг төвлөрүүлэх		
	2.1.3. Үр өгөөжтэй инновацийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэл, хэрэглээ бий болгох санаачлагыг дэмжих	+	+
	2.1.4. Тэргүүлэх чиглэлийн онолын суурь судалгаанд гадаадын эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтдийн хамтын ажиллагааг түлхүү чиглүүлэх	+	+
	2.1.5. Хүрээлэнгээс гадаадын эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулиудад ажиллаж буй эрдэмтдийн судалгааг гаргаж, тэднийг судалгааны төсөл, хөтөлбөрт хамруулах	+	+
	2.1.6. Биологийн олон янз байдлыг хадгалах, хамгаалах, зохистой ашиглахад чиглэсэн онолын судалгааг хөгжүүлэх	+	+
2.2. Монгол орны амьтны аймгийн гарал үүсэл, биологи, экологи онцлог, зүй тогтлыг судлан илрүүлж, экосистемийн тэнцвэрт байдал, биологийн олон янз байдлыг хадгалах, нөөцийг хамгаалах, ашиглах шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах	2.2.1. Монгол орны амьтны аймгийн ангилал зүй, генетик тогтцыг молекул биологийн дэвшилтэт судалгааны арга зүй ашиглан шийдвэрлэх, зүйлийн бүрдлийн шинэчилсэн жагсаалтыг гаргах, ховор амьтдын жагсаалтыг шинэчлэн боловсруулах, зүйлийн хамгааллын статусыг тогтоох	+	+
	2.2.2. Монгол орны нэн ховор, ховор, экосистемийн чухал холбогдол бүхий амьтны биологи, экологийн онцлогийг судлан тогтоох, амьдрах орчныг загварчлах, амьтдын экологи эдийн засгийн үнэлгээг шинэчлэн боловсруулах	+	
	2.2.3. Монгол орны агнуурын холбогдолтой амьтдын тархац, биологи нөөцийг үнэлэн тогтоох зохистой ашиглах нөөцийн хэмжээг тодорхойлох, тусгай зориулалтаар ашиглах амьтдын талаар санал үндэслэл боловсруулах,	+	+
	2.2.4. Хүний хүчин зүйлийн болон уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр амьтдын нөөц, амьдрах орчин, тархац нутагт илрэх өөрчлөлт, зүй тогтлыг илрүүлэх	+	+
	2.2.5. Бүс нутаг монгол орны хэмжээнд тархац нутаг, тоо толгой багасч устах аюулд орсон амьтдыг сэргээн нутагшуулах, зориудын орчинд өсгөн үржүүлэх, удмын санг хадгалах, тогтвортой өсөлтийг хангах дэвшилтэт арга, технологийг нэвтрүүлэх, тогтвортой ашиглах судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэх	+	+
	2.2.6. Монгол орны харь зүйл амьтдын зүйлийн бүрдэл, экологи биологи онцлогийг үнэлэн тогтоох, сөрөг нөлөөллөөс сэргийлэх, мэдээллийн сан үүсгэх	+	+
	2.2.7. Монгол орны хөхтөн, шувуу, шавьж, загас усны амьтдын цуглуулгын сан	+	+



	хөмрөгийг баяжуулж мэдээллийн санг бий болгох, амьтны биет үзүүлэн бүхий үзмэрийн танхимыг байгуулах		
	2.2.8. Нуурын биоценозод гарч буй хувьсал, үүсмэл болон байгалийн нуур, усан сангуудад загасны нөөцийг үнэлэх, хамгаалах зөвлөмж санал боловсруулах, үүсмэл нуурт дасан амьдарч буй загас, хөвөгч болон ёроолын амьтны хэмжээ, биомассын хөдлөл зүйг тогтоох	+	+
2.3. Монгол орны биологийн олон янз байдлыг хадгалах, сэргээн үржүүлэх үндэслэл боловсруулах, ашигт ургамлыг биотехнологийн аргаар үржүүлэх хоёрдогч метаболитын судалгаа хийх, хавдрын эсийг дарангуйлах биологийн идэвхит бодисыг судлах, хавдрын молекул механизм, шалтгааныг тогтоох, оношлогооны цомог гаргах, хувиргасан амьд организмыг илрүүлэх	2.3.1. Монгол орны нэн ховор мазаалай баавгай, хавтгай тэмээ, монгол бөхөн зэрэг амьтдын удмын санг хадгалах, экосистемд чухал ач холбогдол бүхий амьтдын ангилал зүйн асуудлыг орчин үеийн дэвшилтэт техник, технологи, арга зүйг ашиглан шийдвэрлэж, ангилал зүйн судалгаанд молекул биологийн арга зүй өргөн ашиглах	+	+
	2.3.2. Хүний элэгний эрүүл болон хавдарын дээжнүүдээс РНХ, ДНХ болон эдийн lysate бэлдэж уг дээжнүүдийг ашиглаж орчин үеийн молекул биологи, биохимийн аргуудаар хувь хүний генийн олон янз байдал, тэдгээрийн нийлэгжилтийн зохицуулалтанд хавдарын нөлөөгөөр өөрчлөлт орсон эсэхийг судлах	+	+
	2.3.3. Монгол улсад гарган авсан болон импортын хувиргасан амьд организаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдэлийн үнэлгээ хийх, илрүүлэх	+	+
	2.3.4. Хавдарын эсийн үүсэл, ургалт, шилжилт хөдөлгөөнтэй холбогдон нийлэгжилтэнд ордог нь тогтоогдоод байгаа JLP генийн болон адууны <i>Herpesvirus</i> төрлийн шинэ вирусийн судалгааг хийх	+	+
	2.3.5 Монгол орны зарим ховор эмийн болон ашигт ургамлын генофондыг хамгаалах <i>in vitro, ex situ</i> хадгалалтын биотехнологийн үндэслэл боловсруулах, бичил ургамлыг массаар үйлдвэрлэн хувийн хэвшлийн байгууллагад нийлүүлэх	+	+
	2.3.6. Ховордож, устаж буй эмийн болон ашигт ургамлуудын бичил ургамал болон эсийн биомасс дахь метаболитуудын судалгаа хийх, ашигт нэгдлийн агууламжийг нэмэгдүүлэхэд генийн инженерчлэлийн арга зүйг нэвтрүүлэх, дэвшилтэт технологи ашиглах	+	+
2.4. Монгол орны бичил биетний ангилал зүй, генетик нөөцийг судалж, үндэсний сан бий болгох, ашигт өсгөврүүдийг илрүүлж, байгаль орчны	2.4.1. Монгол орны ашигт бичил биетний (дрожж, замаг, бактери, мөөгөнцөр) олон янзын байдлыг хадгалах, төрөл зүйлийн хамаарлыг молекул биологийн төвшинд тогтоон, өсгөврийн санг баяжуулж, нэгдсэн мэдээллийн сан байгуулах, цаашдын судалгаанд ашиглах	+	+



бохирдлыг бууруулах, нөхөн сэргээх, хүнс, тэжээлийн нэмэлт бэлдмэл, өвчин үүсгэгчийн эсрэг үйлчилгээтэй бүтээгдэхүүн гарган авах	2.4.2. Монгол орны бичил биетний генетик нөөцийг ашиглан инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд чиглэсэн судалгааг өргөжүүлэх	+	+
	2.4.3. Органик болон хүнд металлын бохирдлыг бууруулах, ойн хортон устгах чадвартай нөхөн сэргээлтэд ашиглах боломжтой бичил биетний судалгааг хийх	+	+
	2.4.5. Фермент нийлэгжүүлэгч бичил биетний тархцын зүй тогтол, чадавхийг судлан протеаза, амилаза, целлюлаза, аспарагиназа нийлэгжүүлэгч өсгөврүүдийг сонгож хөнгөн, хүнсний болон бусад салбаруудад ашиглах боломжийг тогтоох	+	+
	2.4.6. Монгол орны хөрс, ус, бусад экосистемээс биологийн идэвхт бичил биетнийг илрүүлэх, хүнс тэжээлийн нэмэлт бэлдмэл үйлдвэрлэх технологийн судалгааг хийх	+	+
	2.4.7. Амьтан, ургамал, байгалийн гаралтай био-идэвхт бодисыг илрүүлэх, өвчин үүсгэгчийн эсрэг үйлчлэх механизмыг судлах	+	+
	2.4.8. Эх орны биологийн нөөц баялаг, бичил биетний тухай шинжлэх ухаан танин мэдэхүйн ач холбогдолтой мэдлэг мэдээллийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчлах	+	+
2.5. Оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг нэмэгдүүлж, оюуны бүтээлийг эдийн засгийн эргэлтэнд оруулах	2.5.1. Хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын эрдмийн бүтээл, оюуны өмчийн нэгдсэн жагсаалтыг гаргах	+	+
	2.5.2. Эрдэм шинжилгээний ажилтны оюуны өмч, технологи дамжуулах талаарх мэдлэг чадварыг дээшлүүлэх, сургалтанд хамруулах, оюуны өмч бий болгох, мэдүүлэг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	+	+
	2.5.3. Эрдэм шинжилгээний ажилтны оюуны өмчийн бүтээлийг үр өгөөжтэй ашиглах, үнэлэх, урамшуулах тогтолцоо бий болгож хэрэгжүүлэх	+	+
2.6. Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээлийн чанарыг сайжруулах, олон улсын жишигт хүргэх, импакт фактор бүхий сэтгүүлд нийтлүүлэх өгүүллийн тоог нэмэгдүүлэх, судлаачдын бүтээлийн чанарыг сайжруулах	2.6.1. Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээлд хөндлөнгийн, хараат бус хянан магадлагаа хийх гадаад, дотоодын мэргэжилтэн бүхий редакцийн зөвлөл байгуулан ажиллуулах		+
	2.6.2. Хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын имфакт фактортай гадаадын нэр хүнд бүхий мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийг жил бүр эмхэтгэн нийтийн хүртээл болгох, 1963 оноос хэвлэгдсэн нийт 30 гаруй боть хүрээлэнгийн бүтээлийн цахим эхийг бэлтгэх, хэвлүүлэх	+	+
	2.6.3. Эрдэм шинжилгээний сэтгүүлийн олон улсын стандартыг нэвтрүүлэх	+	+



	2.6.4. Олон улсын импакт фактор бүхий сэтгүүлүүдтэй холбоо тогтоож, хамтран ажиллах, редакцийн зөвлөлд тэргүүлэх эрдэмтдийг ажиллуулах	+	+
	2.6.5. Судлаачдын ажлыг үнэлэх үндсэн шалгуур үзүүлэлтийн нэг импакт фактор бүхий сэтгүүлд нийтлүүлсэн өгүүллийн зохиогчийг урамшуулах тогтолцоог бүрдүүлэх	+	+
2.7. Олон нийтийн экологийн боловсрол, биологийн шинжлэх ухааны мэдлэгийг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх, шинэ мэдлэг түгээн дэлгэрүүлэх	2.7.1. Биологийн шинжлэх ухаан, танин мэдэхүйн хялбаршуулсан цуврал товхимол гаргах, олон улсын стандарт шаардлага хангасан Биологийн мэргэжлийн ном орчуулах	+	+
	2.7.2. Цахим хуудас, мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгслээр шинжлэх ухааны мэдээ мэдээллийг түгээн дэлгэрүүлэх, эрдэмтдийн бүтээлийг сурталчлах	+	+
	2.7.3. Хүрээлэнгийн нээлттэй өдөрлөгийг жил бүр зохион байгуулж гадаад, дотоодын үзэсгэлэнд мэдлэг шингэсэн инновацийн бүтээгдэхүүнээр оролцох	+	+
<b>III стратеги зорилт: ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЖ, СУДАЛГАА БОЛОВСРУУЛАЛТЫН ТААТАЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ</b>			
3.1. Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн дүрмийг мөрдөх, мэдлэг, чадвар, бүтээлийг үнэлэх шалгуурыг шинэчлэн тогтоож, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх	3.2.1. Эрдэм шинжилгээний ажилтанд тавигдах шаардлага, шалгуурыг шинэчлэн тодорхойлж мэргэжлийн ёс зүйн журмыг боловсруулж батлан мөрдүүлж сурталчилах, ёс зүй хэм хэмжээг сахиулах, жендэрийн тэгш байдлыг хангах мөрдөж ажиллах	+	+
	3.2.2. Дотоод, гадаадад мэргэжил эзэмшсэн чадварлаг эрдэм шинжилгээний ажилтныг ажиллуулах нөхцөл бололцоогоор хангах	+	+
	3.2.3. Үр бүтээлтэй ажиллаж буй залуу эрдэм шинжилгээний ажилтны гадаадын докторантурт элсэн суралцахад нь дэмжлэг үзүүлэх	+	+
	3.2.4. Гадаадад Монголын болон тухайн улсын засгийн газрын тэтгэлэгээр докторантурт суралцахаар тэнцсэн тохиолдолд суралцах хугацааны НДШ-ийг хүрээлэнгээс төлж, харин төгсөөд эргэж хүрээлэндээ ажиллах тухай гэрээ байгуулах	+	+
	3.2.5. Залуу эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтанд олгох судалгааны грант, докторын дараах судалгааны тэтгэлгийн тоог нэмэгдүүлэх	+	+
	3.2.6. Эрдэм шинжилгээний ажилтныг судалгааны үр дүнгээ олон улсын сэтгүүлд хэвлүүлэхэд зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх	+	+
	3.2.7. Олон улсын төсөл хөтөлбөр, дотоодын санхүүгийн эх үүсвэрийг тулгуурлан эрдэм шинжилгээний ажилтны цалин орлогыг нэмэгдүүлэх	+	+



3.2. Эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтны ажиллаж, амьдрах нөхцөл, хангамжийг сайжруулах	3.2.1. Ажилтан ажиллагсдын орон сууцны нөхцөлийг сайжруулахад анхааран дэмжлэг үзүүлэх	+	+
	3.2.2. Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хангах	+	+
	3.2.3. Их, дээд сургуулиудын ахисан түвшний сургалтанд хичээл заах, магистр, докторын ажил удирдах эрдэм шинжилгээний ажилтнуудын тоог нэмэгдүүлэх	+	+
3.3. Лабораторийн баазыг олон улсын жишигт нийцүүлэн бэхжүүлэх	3.3.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд хүрээлэнгийн 9 лабораторийн тоног төхөөрөмжийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх, өргөтгөх, лаборатори нэгжийг орчин үеийн судалгааны багаж хэрэгслэл, тоног төхөөрөмж, эм урвалжаар хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	+	+
	3.3.2. Биологийн идэвхит бэлдмэл туршилтын биоцехийг эрүүл ахуй, үйлдвэрлэлийн шаардлага хангасан нөхцөлийг бүрдүүлэн засварлах, нэн шаардлагатай багаж хэрэгслэл, тоног төхөөрөмжөөр тоноглох	+	+
	3.3.3. Монгол орны ховор болон нэн ховор амьтдын үрийн шингэнийг хадгалах лабораторийг шинээр байгуулах	+	+
	3.3.4. Гидробиологи, биохими, физиологийн туршилт судалгааны лабораторийг шинээр байгуулан овор хэмжээ бага хээрийн нөхцөлд ажиллах боломжтой зөөврийн багаж хэрэгслэл, төхөөрөмжөөр хангах	+	+
	3.3.5. Дотоодын эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулиудтай хамтран “дундын ашиглалтын лаборатори” байгуулан хамтран ашиглах	+	+
3.4. Мэдээллийн технологийн орчин үеийн шаардлагад нийцсэн нарийн мэргэшлийн ном, товхимол бүхий уншлагын танхим байгуулах	3.4.1. Мэдээллийн технологийн орчин үеийн шаардлагад нийцүүлсэн уншлагын танхим тохижуулан олон улсын өндөр зэрэглэлтэй мэргэжлийн ном, сэтгүүлийн хангамж, ашиглалтыг сайжруулах	+	+
	3.4.2. Уншлагын танхимын ном, хэвлэлийн фондыг мэргэшлийн ном, товхимол, эрдэм шинжилгээний сэтгүүл бусад шаардлагатай мэдээллээр баяжуулах, Ахмад эрдэмтдийн номын хандивыг идэвхжүүлэх	+	+
3.5. Хүрээлэнгийн барилга, байгууламжийг засварлах, өргөтгөх	3.5.1. Хүрээлэнгийн нэгдсэн байрны дээвэр, гадна дотно засвар, цахилгааны болон халуун хүйтэн усны шугам сүлжээг шинээр солих, их засварын ажлын төсвийг жил бүрийн улсын төсөвт үе шаттайгаар суулган хэрэгжүүлэх	+	+
	3.5.2. Хүрээлэнгийн биоцех, гражийн барилга засвар, өргөтгөлийн ажлыг гүйцэтгэх	+	





	3.5.3. Урсгал засварын ажлыг цаг алдалгүй, чанартай хийж гүйцэтгэх	+	+
<b>IV стратеги зорилт: ТӨЛӨВЛӨГӨӨТ САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЭХ</b>			
4.1. Санхүүжилтийн тогтолцоог олон эх үүсвэрээс бүрдүүлэх, хүрээлэн-Монголд үйл ажиллагаа явуулдаг олон улсын төсөл хөтөлбөрүүд, орон нутаг, хувийн хэвшлийн түншлэлийг өргөтгөж, судалгаа, боловсруулалт, инновацийн үйл ажиллагааг өргөжүүлэх	4.1.1. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх ажил үйлчилгээ, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг үе шаттайгаар нэмэгдүүлэх, үр өгөөжийг дээшлүүлэх	+	+
	4.1.2. Гадаадын байгууллага, улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх ШУТ-ын төслүүд, Монголд үйл ажиллагаа явуулдаг олон улсын төсөл хөтөлбөрүүд, БОАЖЯ, Аймаг орон нутгийн байгаль хамгаалах алба, Тусгай хамгаалалттай нутгийн хамгаалалтын захиргаад, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах замаар санхүүжилтийн олон эх үүсвэрийг бүрдүүлэх	+	+
	4.1.3. Аймаг орон нутгийн байгаль хамгаалах алба, Тусгай хамгаалалттай нутгийн хамгаалалтын захиргаадтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, биологийн олон янз байдлын болон “шүхэр” зүйлийн хамгааллын менежмент, агнуур зохион байгуулалтын судалгааг гүйцэтгэх шалгаруулалтад оролцон санхүүжилтийн эх үүсвэр бий болгох	+	+
	4.1.4. Биологийн төрөл зүйлийн компонент бүхий олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрүүдтэй нягт хамтран ажиллаж гэрээт ажлуудыг гүйцэтгэх	+	+
	4.1.5. Байгалийн нөөц ашиглан үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагад байгаль ан амьтан хамгааллын чиглэлээр мэргэжлийн туслалцаа үзүүлэх, хамтарсан төсөл хэрэгжүүлэх	+	+
4.2. Томоохон зорилтыг шийдвэрлэхэд гадаадын төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг төвлөрүүлэх	4.2.1. Гадаадын улс орны шинжлэх ухааны байгууллага, судлаачдын баг, Монгол улс дахь олон улсын байгууллага, хөгжлийн хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах, санамж бичиг, гэрээ хэлцэл байгуулах, хамтарсан төсөл хөтөлбөрийн тоо, оролцогсдын хамрах хүрээг нэмэгдүүлэх	+	+
<b>V стратеги зорилт: ИННОВАЦИ, ГАРААНЫ КОМПАНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ СУДАЛГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, ОНЦЛОГТ УЯЛДУУЛАН ХӨГЖҮҮЛЭХ</b>			
5.1. Судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэнд оруулах инновацийн тогтолцоог	5.1.1. Хүрээлэнгийн дэргэд Гарааны компани байгуулах, лаборатори, нэгжийн хэрэгжүүлж буй эрдэм шинжилгээ судалгааны ажлыг инноваци, өндөр технологитой уялдуулах, судлаачдын мэдүүлсэн патентыг хүрээлэнгийн өмчлөлд шилжүүлэн бүртгэх,	+	



байгууллагын түвшинд бүрдүүлэх	лицензийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах		
	5.1.2. Гарааны компани, инновацийн төслөөс гарсан үр дүн, бүтээгдэхүүний зохиогчийн эрх, патент, стандарчилах, сертификатжуулах, технологийн үнэлгээ хийлгэх, хөрөнгө оруулагч талтай гэрээ байгуулах, гарааны компанийг хөгжүүлэх зэрэг сургалт, мэдлэгийг олгох	+	+
	5.1.3. Инновацийн үйл ажиллагааг хариуцсан ажилтныг томилон ажиллуулах, сургалтад хамруулах, мэргэшсэн боловсон хүчний тоог нэмэгдүүлэх	+	
	5.1.4. Оюуны өмчийн эрхийн хамгаалал, технологи дамжуулал, инновацийн үйл ажиллагаа эрхлэх арга зүй эзэмшүүлэх ахисан түвшний сургалтанд хамруулах улмаар оюуны өмчийн /патент, зохиогчийн эрх, ашигтай загвар/ тоог нэмэгдүүлэх	+	+
	5.1.5. Шинжлэх ухаан, технологи, инновацийн нээлттэй өдөрлөг зохион байгуулах, үзэсгэлэнд оролцох	+	+
<b>VI стратеги зорилт: ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ</b>			
6.1. Хил залгаа бүс нутаг, технологи өндөр хөгжилтэй улс орны болон олон улсын шинжлэх ухааны байгууллагуудтай хамтран ажиллах бодлого зохицуулалтын үйл ажиллагааг оновчтой төлөвлөж хамтын ажиллагааг өргөжүүлэх	6.1.1. Биологийн шинжлэх ухааны салбар чиглэлээр олон улсын байгууллагуудад элсэх гишүүнчлэлээ нэмэгдүүлж, үйл ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэх	+	+
	6.1.2. Биологийн олон янз байдал, амьтны экологи, бичил биетний биологийн болон биотехнологи, молекул биологийн судалгааны хамтарсан лаборатори, хээрийн судалгааны суурин байгуулах, мэргэжилтэн солилцоог өргөжүүлэх, хамтын бүтээл туурвих	+	+
	6.1.3. "Бүс ба автозамын Хятад-Монгол-Оросын коридорын дагуух экологийн аюулгүй байдлын үнэлгээ хийх судалгаа ба авах арга хэмжээ (CMRC судалгаа)" төслийг хэрэгжүүлж эхлэх, хамтын ажиллагааны гэрээ санамж бичгийг холбогдох талуудтай байгуулах	+	+
6.2. Монгол Оросын хамтарсан Биологийн иж бүрэн экспедици (МОХБИБЭ)-ийн хүрээнд хийх судалгааны ажлуудыг өргөжүүлэх, хамтын ажиллагааг идэвхжүүлэх	6.2.1. Хамтарсан экспедицийн хүрээнд хэрэгжүүлэх судалгаа шинжилгээний ажлын зарим чиглэл, отрядын үйл ажиллагааг хүрээлэнгийн стратегийн зорилт арга хэмжээтэй уялдуулан төлөвлөж, эрдэм судлалын ажлын хамрах хүрээ, онол, арга зүйн түвшин, үр дүнг дээшлүүлэх, мониторинг судалгааны цэг нутгийг тогтмол ажиллуулах	+	+
	6.2.2. МОХБИБЭ ажиллаж эхэлсний хагас зуун жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх	+	+



	ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллах /Олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, үзэсгэлэн гаргах, ном бүтээл хэвлүүлэх/		
	6.2.3. МОХБИБЭ-ийн шугамаар ОХУ-ын хүрээлэн байгууллагад ажиллах эрдэмтэн судлаачдын тоо, хээрийн судалгааны мэдээ эх хэрэглэхүүнийг боловсруулан хамтын бүтээл хэвлүүлэх, олон улсын хурал, сургалт семинар зохион байгуулах давтамж тоо хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх	+	+
6.3. Олон улсын нэр хүндтэй их сургууль, шинжлэх ухааны байгууллагатай хамтран мэргэжилтэн боловсон хүчин бэлтгэх, эрдэмтэн солилцоо хэрэгжүүлэх	6.3.1. Эрдэм шинжилгээний ажилтнуудыг олон улсад зохиогдох эрдэм шинжилгээний хурал зөвлөгөөнд оролцуулах, сургалтад хамруулах ажлыг өргөжүүлэх	+	+
	6.3.2. Технологи өндөр хөгжсөн улс орнуудад нарийн мэргэшсэн эрдмийн зэрэгтэй боловсон хүчин бэлтгэх зорилтын хэрэгжилтийг эрчимжүүлэн 2021 онд э/ш-ний ажилтны 40-өөс доошгүй хувьд хүргэх	+	+
	6.3.3. Гадаадын эрдэмтэн судлаачдыг урьж лекц, семинар, сургалт зохион байгуулах	+	+



## ЗУРГАА. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНХҮҮГИЙН ХҮРЭЭ, БОЛОМЖ

Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн хүрээг гадаад болон дотоод, оюуны болон биет хөрөнгө оруулалт гэсэн хэсгүүдээр тодорхойлж байна.

Дотоод боломж	Гадаад боломж
<p>Стратеги төлөвлөгөөний хүрээнд хэрэгжих шинэ сэдэв, төслүүдийг нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглүүлэх, үр дүн нь Монголын шинжлэх ухаанд дорвитой хувь нэмэр оруулсан байх, үр дүн нь шууд болон шууд бус хэлбэрээр бүтээгдэхүүн болж үр ашгаа өгдөг байхаар боловсруулан улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.</p> <p>Онолын суурь судалгаа, шинжлэх ухаан технологийн төслийн судалгааны материалуудын бодит өртгийг нарийвчлан тодорхойлох, түүнийг хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн болгон зах зээл дээр борлуулах замаар жилдээ тодорхой хэмжээний мөнгөн орлого олж, Хүрээлэнгийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн үндсэн эх үүсвэрийн нэг болгоно.</p> <p>Төрийн болон орон нутаг, хувийн хэвшлийн бизнесийн байгууллагуудтай хамтран шинжлэх ухаан, технологийн бүхий л хэлбэрийн төслүүдийг хэрэгжүүлж хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг татна.</p> <p>Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрүүдэд судалгаа шинжилгээний ажлын чиглэлийн дагуу хамрагдан оролцож, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудтай хамтран ажиллах замаар санхүүжилтийн нэгэн эх үүсвэрийг бий болгоно.</p>	<p>Монгол орны эрс тэс уур амьсгал, байгалийн нөхцөлд зохицсон Төв Азийн эндемик, Монгол орноос өөр нутагт байхгүй биологийн төрөл зүйл олонтой, харьцангуй байгалийн унаган төрхөө хадгалан үлдсэн зэрэг онцлог байдал гадаадын эрдэмтэн судлаачдын сонирхлыг байнга татаж байдаг давуу талд тулгуурлан гадаад хамтын ажиллагааг техникийн болон судалгааны төслүүд хэлбэрээр хэрэгжүүлж гадаад санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлнэ.</p> <p>Олон улсын түвшинд болон гадаад түншүүдтэй хамтран ажиллаж хэрэгжүүлэх техникийн үйл ажиллагааны хүрээнд судалгааны багаж тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах, боловсон хүчний чадавхыг сайжруулах, хамтын эрдмийн бүтээлийг хэвлүүлэхэд онцгой анхааран гэрээ санамж бичгүүдэд тусган үйл ажиллагааны зардал олох нөхцөлийг бүрдүүлнэ.</p>